

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР
2024 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Аймгийн хэмжээнд шалгаруулдаг “Шилдэг төрийн албан хаагч-25” журмын дагуу тогтвор суурьшилтай ажиллаж нарийн мэргэшлийн болон уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг орон нутагт түгээн дэлгэрүүлэх, ноцтой хүндрэлээс урьдчилан сэргийлж ажилласан, ажил мэргэжлийн ур чадвар, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа, дутагдал гараагаагүй өндөр ур чадвар, бүтээлч сэтгэлгээтэй бусдыгаа манлайлан ажилласан 3 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг шилдэг төрийн албан хаагчаар шалгаруулж тус бүр 1,000,000 нийт 3,000,000 төгрөгөөр шагнуулсан.

Үүнд: Нэгдсэн эмнэлгийн мэдээгүйжүүлэгийн эмч Б.Түвшинтөгс, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн дарга Х.Чирчинсүрэн, Баянжаргалан сумын эрүүл мэндийн төвийн эх баригч Д.Мөрөнтамир нар шалгарсан.



Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” хөтөлбөрт тус онд эрүүл мэндийн салбар 24 албан хаагч хамрагдаж, 121,8 сая төгрөгийн дэмжлэг авч нийгмийн асуудлаа шийдвэрлүүлж, мэдлэг мэргэшлээ дээшлүүлсэн байна.

АШУҮИС-ийн Дорноговь салбар сургууль, Этүгэн их сургууль, Ач анагаах ухааны дээд сургуулийн лабароторийн техникч, сувилахуй, эм зүй, хүний их эмчийн ангид суралцаж байгаа төгсөх ангийн 7 оюутанд 16,7 сая төгрөгийн сургалтын төлбөрийн асуудлыг шийдвэрлэлээ.



Аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэшлийн эмч болон сумын эрүүл мэндийн төвийн эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор Нэгдсэн эмнэлгийн мэдрэлийн эмч Н.Гүрбадам, бөөрний эмч Б.Ган-Эрдэнэ, дүрс оношилгооны эмч Э.Баяраа, П.Мягмарсүрэн, мэдээгүйжүүлэгийн эмч Б.Түвшинтөгс, Эрдэнэдалай сумын эрүүл мэндийн төвийн их эмч Ж.Мөнхбат, Эрүүл мэндийн газрын ахлах мэргэжилтэн П.Оюунчимэг, Дэлгэрахангай сумын эрүүл мэндийн төвийн бүртгэл мэдээллийн ажилтан А.Номинчимэг нарт орон байрны дэмжлэг тус бүр 10,000,000 төгрөг нийт 8 албан хаагчдад 80,000,000 төгрөгийг олголоо.

Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх зорилгоор Эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга Б.Саруулцэцэг, халдварт бус



өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Цэрэнчунт нарт магистрын сургалтын төлбөр 2,000,000 төгрөг шийдүүлсэн.

Боржигон мандал өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Ч.Сумъяад эрүүл мэндийн дэмжлэг 6,000,000 төгрөгийг олголоо.



Эрдэнэдалай сумын эрүүл мэндийн төвийн их эмч Ё.Сийлэгмаа, Өлзийт мандал өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч Б.Баярцэрэн нарт гэрийн авах дэмжлэг 10,000,000 төгрөг олголоо.



Гадаад хамтын ажиллагааны хүрээнд Эрдэнэдалай сумын эрүүл мэндийн төвийн их эмч Ж.Мөнхбат, Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн эмч Э.Манал нарыг БНСУ-д нарийн мэргэшлийн чиглэлээр богино хугацааны сургалтад хамруулахаар 5,000,000 төгрөг Нэгдсэн эмнэлгийн нүдний эмч Б.Цэрэндулам индонез улсад сургалтад хамруулж 2,000,000 төгрөгийг тус тус шийдвэрлэлээ.



ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД АЖИЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН АСУУДАЛ,
ШАГНАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *Г.ЦЭРЭННАДМИД* Г.ЦЭРЭННАДМИД

ХЯНАСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА *Б.АЛТАНТӨГС* Б.АЛТАНТӨГС

